

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ, САНГИЙН ЯАМ
БОЛОН БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ,
БАЙГАЛЬ ОРЧНЫ КОРПОРАЦ ХООРОНДЫН
МОНГОЛ УЛСЫН УЛААНБААТАР ХОТ БОЛОН 21 АЙМГИЙН ТӨВД АГААРЫН
ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ХАРУУЛ СУУРИЛУУЛАХ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР
ХЭЛЭЛЦЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ

Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам (цаашид "БОАЖЯ" гэх) Монгол Улсын Сангийн яам (цаашид "СЯ" гэх) болон Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын Байгаль орчны яам (цаашид "БОЯ" гэх), БНСУ-ын Байгаль орчны корпорац (цаашид "БОК" гэх) хамтран Монгол Улсын Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд агаарын чанарын хяналтын харуул суурилуулах, чадавхыг бэхжүүлэх төсөл хэрэгжүүлэх талаар (цаашид "Төсөл" гэх) зөвлөлдөх хэлэлцүүлгийг үе шаттайгаар зохион байгуулав.

Талууд энэхүү хэлэлцээний тэмдэглэлд (цаашид "ХТ" гэх) гарын үсэг зурсны дараа Төсөл хэрэгжинэ гэсэн ойлголттойгоор түүнд хавсаргасан ажлын даалгаварт дурдсан асуудлыг тус тусын Засгийн газарт танилцуулахаар тохиролцов.

Хэлэлцээний тэмдэглэлийг монгол, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдэж Талуудын төлөөлөгчид гарын үсэг зурав.

Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамыг төлөөлж:



Бат-Өлзийн Бат-Эрдэнэ
Сайд

Монгол Улсын Сангийн яамыг төлөөлж:



Болдын Жавхлан
Сайд

Бүгд Найрамдах Солонгос Улсын Байгаль орчны яамыг төлөөлж:



Ва Жин Хан
Сайд

Бүгд Найрамдах Солонгос Улсын Байгаль орчны корпорацыг төлөөлж:



Бюнгок Ан
Дарга

Ажлын даалгавар

I зүйл. Төслийн тухай

1. Төслийн нэр

Монгол Улсын Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд мэдээллийн технологид суурилсан хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын нэгдсэн системийг бий болгох төсөл

2. Зорилго

А. Монгол Улсад хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын автомат суурин харуулуудыг байгуулж, ашиглах замаар агаарын чанарын менежментийн чадавхыг сайжруулна.

В. Агаарын чанарын хяналтын суурин харуулуудыг байгуулснаар бодит мэдээлэлд тулгуурласан бодлого, төлөвлөгөө боловсруулах, агаарын бохирдлоос үүдэлтэй амьсгалын замын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, агаарын чанарын менежментийн чадавхыг бэхжүүлнэ.

3. Төслийн үргэлжлэх хугацаа, хэрэгжүүлэх хуваарь

Төслийг 2023-2026 онд хэрэгжүүлнэ. Төслийн хугацааг өөрчилж болох бөгөөд хуваарийг Хавсралт 1-д тусгасан болно.

4. Төслийн байршил

Улаанбаатар хот, Монгол Улсын 21 аймаг (Хавсралт 2.)

5. Төслийн төсөв

А. БНСУ-ын Байгаль орчны яам 8,914,729 ам.доллараас (11,500,000,000 вон*) илүүгүй төсөв гаргана. Валютын ханшийн хэлбэлзэл гарсан тохиолдолд Хэлэлцүүлгийн тэмдэглэлд заасан Солонгосын вон (KRW)-ы ханшаар тооцно.

*Валютын ханш: 1 ам. доллар= 1290 вон

В. Монгол Улсын БОАЖЯ нь 2 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт заасан үүргийг биелүүлэх, мөн Төслийн тогтвортой, бие даасан үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг гаргана.

6. Төслийн хамрах хүрээ

Талууд төслийн зорилгод хүрэхийн тулд төслийн дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг хамтран хэрэгжүүлнэ.

А. Бүрэлдэхүүн хэсэг 1. Агаарын чанарын хяналтын харуул суурилуулах:

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь Монгол Улсын Улаанбаатар хот болон 21 аймгийн төвийн агаарын чанарыг сайжруулах, хүн амын эрүүл мэндэд хувь нэмэр оруулах зорилгоор агаарын чанарын харуулуудыг суурилуулахад оршино.

- 1) Агаарын чанарын хяналтын суурин автомат харуул байгуулах ба харуул тус бүр агаарын чанарыг хэмжих төхөөрөмжүүд (бүх станцад PM2.5, SO2, NOx, хөдөлгөөнт харуулыг оруулан 3 харуулд CO, O3, PM10 үзүүлэлтийг нэмэлтээр хэмжинэ), цаг агаарын хэмжилтийн хэрэгсэл (температур, чийгшил, салхины чиглэл, салхины хурд), өгөгдөл дамжуулах програм болон дээж авах төхөөрөмж, айр-кондиционер, халаагч, тоног төхөөрөмж суурилуулах тавиур гэх мэт бусад төхөөрөмж багтана.
- 2) Агаарын чанарын харуулыг суурилуулж зүгшрүүлэх хүртэлх үйл ажиллагааг дэмжинэ.
- 3) Агаарын чанарын харуулын багаж, тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх гарын авлага болон бусад баримт бичгийг бэлтгэнэ.

Б. Бүрэлдэхүүн хэсэг 2. Агаарын чанарын мэдээллийн систем:

- 1) Олон нийтэд агаарын чанарын мэдээллийг түгээх системийг бүтээх, хөгжүүлэх.
- 2) БОАЖЯ эсхүл хариуцагч байгууллагад агаарын чанарын мэдээллийг цуглуулах, хадгалах сервер болон сүлжээний тоног төхөөрөмж, бусад туслах хэрэгслийг худалдан авч нийлүүлэх.

В. Бүрэлдэхүүн хэсэг 3. Монгол дахь чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр:

- 1) БНСУ-ын мэргэжилтнүүд агаарын чанарын хяналтын харуул суурилуулах, ажиллуулахтай холбоотой техникийн асуудлаар Монголын талын мэргэжилтнүүдэд шаардлагатай техникийн заавар, зөвлөгөө өгнө.
- 2) Агаарын чанарын харуул (байрны хамт) суурилуулах ажлыг Солонгосын мэргэжилтнүүд удирдаж явуулна.
- 3) Тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Монголд ажиллах мэргэжилтний тоо, ажиллах хугацаа өөрчлөгдөж болно. Бусад асуудлыг Талууд цаашид зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.
- 4) Агаарын чанарын харуулын ашиглалтын талаар техникийн сургалт семинарыг Монгол Улсад зохион байгуулна.

Г. Бүрэлдэхүүн хэсэг 4. БНСУ-д чадавх бэхжүүлэх хөтөлбөр:

- 1) Агаарын чанарын хяналт шинжилгээний чиглэлээр БНСУ-ын шилдэг туршлагыг судалж, агаарын чанарын харуулын суурилуулалт, ашиглалтын тухай хууль тогтоомж, БНСУ-ын агаарын чанарын хяналт шинжилгээ, менежментийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцана.
- 2) Монгол Улсын агаарын чанарын хяналтын системийн үйл ажиллагаанд тохирсон мэдээллийн сангийн менежментийн сургалтыг зохион байгуулна.

7. Хэрэгжүүлэгч байгууллага

А. Хоёр улсын Засгийн газрыг Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Байгаль орчны яам тус тус төлөөлж Төслийг хамтран хэрэгжүүлнэ.

Б. БНСУ-ын Байгаль орчны корпорац нь БНСУ-ын Байгаль орчны яамны захиалгаар уг төслийг хэрэгжүүлэх албан ёсны хэрэгжүүлэгч байгууллага юм.

8. Хамтарсан зохицуулах хороо

А. Талууд төслийн Хамтарсан зохицуулах хороог байгуулж ажиллуулна. Хороо нь төслийг хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг тогтооно.

Б. Хорооны чиг үүрэг болон үйл ажиллагааны бусад асуудлыг Талуудын зөвшилцсөнөөр тодорхойлно.

9.Талуудын хамтын ажиллагаа

А. Энэ зүйлийн 2 дугаар хэсэгт заасан төслийн зорилгод хүрэхийн тулд Монгол Улсын БОАЖЯ болон БНСУ-ын БОЯ, БОК хамтран ажиллана.

Б. Талууд төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой болон урьдчилан тооцоолоогүй асуудлыг шийдвэрлэхийн тулд хүчин чармайлт гаргаж ажиллана.

II зүйл. Талуудын үүрэг

1. БНСУ-ын Байгаль орчны яам болон Байгаль орчны корпорацийн үүрэг:

БНСУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу, 1 дүгээр зүйлийн 5 дугаар хэсэгт заасан 8,914,729 ам.доллар (11,500,000,000 вон)-оос илүүгүй төсвийг БНСУ-ын БОЯ-ны нэрийн өмнөөс БОК зарцуулж, 2023-2026 онд төслийн хугацаанд дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Шаардлагатай бол дараах дэлгэрэнгүй төлөвлөгөөг Талууд харилцан зөвшилцсөнөөр өөрчилж болно.

А. Агаарын чанарын харуулуудыг байгуулах, үйл ажиллагааг дэмжих

1) БОК агаарын чанарын харуулыг байгуулж, багаж, тоног төхөөрөмжийг суурилуулна:

- а) 3 харуулын хэмжих үзүүлэлт нь $PM_{2.5}$, SO_2 , NO_x , CO , O_3 , болон PM_{10} байна
- б) 19 харуулын хэмжих үзүүлэлт нь $PM_{2.5}$, SO_2 , NO_x байна

* Хяналтын харуул, бүс нутаг бүрийн хэрэгцээ шаардлагаас хамааран хэмжих үзүүлэлтүүд өөр байж болно.

2) БОК мөн цаг агаарын хэмжих хэрэгсэл (температур, чийгшил, салхины чиглэл, салхины хурд) болон бусад төхөөрөмжийг (агаарын сорьц дамжуулах төхөөрөмж, айр-кондиционер, халаагч, тог баригч, компьютер гэх мэт) суурилуулна.

3) БОК агаарын чанарын харуулын багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтын гарын авлагыг боловсруулна.

4) БОК агаарын чанарын харуулын багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтын стандарт ажиллагааны заавар боловсруулна.

Б. Агаарын чанарын мэдээллийн системийн хөгжүүлэлт

1) БОК нь:

- а) Шинээр байгуулагдах Агаарын чанарын мэдээллийн системийг хөгжүүлж, системийн сервер болон бусад тоног төхөөрөмжийг ЦУОШГ-т байрлуулна.

- b) Монгол Улсын төслийн багтай хамтран Агаарын чанарын мэдээллийн системийг хөгжүүлэх үйл явцад хяналт тавих мэргэжилтэнг Монгол Улсад ажиллуулна.
- c) Агаарын чанарын мэдээллийн системийг хөгжүүлсний дараах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

- 2) Агаарын чанарын өгөгдлийг цуглуулах, боловсруулах, олон нийтэд түгээхэд ашиглах чадвартай мэдээллийн технологийн системийг хөгжүүлнэ.
- 3) Монгол Улсын Агаарын чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээний мэдээллийн систем, зураг төсөл боловсруулах, хөгжүүлэх, агаар.mn системийг боловсронгуй болгох асуудлыг цаашид Талууд хооронд зөвлөлдөх замаар сайжруулж болно.

В. БНСУ-ын мэргэжилтнүүдийг Монголд ажиллуулах

1. БОК нь төслийн менежментийг хариуцах мэргэшсэн мэргэжилтнүүдийг Монгол Улсад ажиллуулах бөгөөд мэргэжилтнүүд нь дараах үндсэн чиг үүрэгтэй байна:

- a) Шинэ сүлжээний харуулуудын зураг төслийг боловсруулах үе шатаас эхлээд суурилуулж дуусах хүртэлх төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, оролцогч талуудтай хамтран ажиллана.
- b) Агаарын чанарын харуул суурилуулахад БОАЖЯ болон БОК-тай хамтран ажиллана.
- c) Монгол Улсад чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- d) Агаарын чанарын харуулуудын үйл ажиллагаа, менежментэд хяналт тавина.

Г. Чадавх бэхжүүлэх хөтөлбөрүүд

- 1) БОК нь дараах төрлийн чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ:
 - a) Агаарын чанарын хяналт, агаарын бохирдлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр техникийн түвшний болон удирдлагын түвшний чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөрийг БНСУ-д зохион байгуулна.
 - b) Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөрийг Монгол Улсад зохион байгуулна.
- 2) БОК нь өөрсдийн журмын дагуу Солонгост суралцагчийн нислэгийн тийз, байр, амьдрах зардал зэрэг чадавхыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийн зардлыг хариуцна.
- 3) Сургалтын дэлгэрэнгүй мэдээлэл, суралцагчдын тоо, суралцах хугацааг Талууд харилцан зөвшилцсөнөөр төсвийн хүрээнд өөрчилж болно.

2. БОАЖЯ болон Сангийн яамны хүлээх үүрэг

Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс хоёр яамд төслийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана. Шаардлагатай бол оролцогчид харилцан зөвшилцсөнөөр дараах нөхцөлүүдийг өөрчилж болно.

А. Ерөнхий захиргааны арга хэмжээ

БОАЖЯ нь:

- a) Төслийн хүрээнд БНСУ-ын БОК-тай хамтран ажиллах менежментийн багийг байгуулна.
- b) Төсөл хэрэгжих хугацаанд болон төсөл хэрэгжиж дууссаны дараа агаарын чанарын харуулуудын тасралтгүй үйл ажиллагаа, засвар үйлчилгээний урсгал зардал болон хүний нөөцийг нэмэгдүүлэхэд шаардлагатай зардлыг БОАЖЯ төсөвтөө тусган ажиллана.
- c) Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу холбогдох бүх эрх бүхий байгууллагаас шаардлагатай зөвшөөрлийг авах, Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль эрх зүйн бүхий л асуудлыг шийдвэрлэнэ.
- d) Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгнө. Эдгээр мэдээлэл, баримт бичгийг монгол болон англи хэл дээр бичгэн хэлбэрээр гаргаж өгнө.

Б. Агаарын чанарын харуулуудыг суурилуулах, ажиллуулахад дэмжлэг үзүүлэх

БОАЖЯ нь:

- a) Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд Монголын талаас шаардлагатай ажилтнуудыг томилж, ажиллуулна.
- b) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зураг төслийн зөвшөөрөл олгохоос эхлээд бүтээн байгуулалтыг дуусгах хүртэлх бүх захиргааны үйл ажиллагааны зардлыг хариуцна.
- c) Шал, цахилгаан суурилуулах, холбооны шугам татах, хашаа барих зардлыг хариуцна.
- d) Цахилгаан, харилцаа холбооны төлбөр болон бусад байгууламжийн үйл ажиллагааны сарын үйлчилгээний төлбөрийг хариуцна.
- e) Харуулын үндсэн байрнаас бусад агаарын чанарын хяналтын харуулуудыг суурилуулах талбайгаар хангана.
- f) Төслийн дараах менежментийн үйл ажиллагаанд бэлтгэнэ (агаарын чанарын харуулуудыг ажиллуулах төсөв, хүний нөөц).
- g) Төслийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой цаг уурын болон агаар мандлын нөхцөл байдлын талаарх статистик мэдээллийг багтаасан холбогдох мэдээллээр хангах.

В. Системийг хөгжүүлэх арга хэмжээ

БОАЖЯ нь:

- a) Бүх зураг төсөл, бүтээн байгуулалтын төлөвлөгөөг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батална.
- b) Боловсруулалтын ажилд шаардлагатай холбогдох бичиг баримт, зургийг англи, монгол хэл дээр гаргаж өгнө.
- c) Тохиромжтой серверийн өрөөгөөр хангаж, аюулгүй байдал болон кибер аюулгүй байдлын арга хэмжээг авна.

- d) Цахилгаан, харилцаа холбоо, халаалт, агааржуулалт, хөргөлт гэх мэт мэдээллийн технологийн системийг ажиллуулахад хангалттай суурь дэд бүтцийг бий болгоно.

Г. БНСУ-ын БОЯ, БОК-аас олгосон тоног төхөөрөмжийн талаар авах арга хэмжээ

1. Сангийн яам нь:

- a) Төслийг хэрэгжүүлэх зорилгоор импортоор оруулж ирсэн аливаа тоног төхөөрөмж, материалыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу гаалийн албан татвар, НӨАТ-аас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ.

БОАЖЯ нь:

- a) Тоног төхөөрөмж, материалыг буулгах, дотоод тээвэрлэлт, гаалиас /боомтоос төслийн талбайд хүргэх даатгалын зардлыг хариуцна.
- b) Төслийн хугацаанд болон дараа нь БНСУ-ын БОЯ, БОК-аас олгосон үнэ төлбөргүй баталгаат бараа, хэрэглээний материалаас бусад тоног төхөөрөмж, материалын хадгалалт, ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг хариуцна.
- c) БНСУ-ын БОЯ, БОК-аас олгосноос бусад төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, систем болон бусад материалыг нийлүүлнэ.
- d) Энэхүү төслийн тоног төхөөрөмжийн баталгаат хугацаа дууссанаас хойш жил бүр агаарын чанарын хяналтын станцыг ажиллуулахад шаардлагатай эд анги, хэрэглээний материалыг худалдан авахад зориулж хяналтын станц, тоног төхөөрөмжийг суурилуулах зардлын 3 орчим хувийг төсөвт тусган гаргана.
- e) БНСУ-ын БОЯ, БОК-аас олгосон тоног төхөөрөмж, материалыг зөвхөн төслийг хэрэгжүүлэх зорилгоор ашиглана.

Д. Чадавх бэхжүүлэх хөтөлбөрүүд

1. БОАЖЯ нь:

- a) БНСУ дахь сургалтын хөтөлбөрт орон нутгаас оролцох албан хаагчдыг томилно.
- b) БНСУ-д зохион байгуулах сургалтад захиргааны дэмжлэг үзүүлнэ.
- c) Семинар зохион байгуулах танхим гаргаж өгнө (зардлыг хариуцахгүй).

Е. Солонгосын мэргэжилтнүүдэд зориулсан арга хэмжээ

1. БОАЖЯ нь:

- a) Солонгос мэргэжилтнүүдэд ажлын байрны зөвшөөрөл, даатгал, эмнэлгийн тусламж авахад нь захиргааны дэмжлэг үзүүлнэ.
- b) БНСУ-ын мэргэжилтнүүдийг санаатай буруутай үйл ажиллагаа, илт хайхрамжгүй байдлаас бусад тохиолдолд Монгол Улсад даалгасан үүрэг даалгаврыг гүйцэтгэх явцад гарсан, эсхүл тэдгээртэй бусад байдлаар холбоотой гомдлоос хамгаална.

- с) Солонгосын мэргэжилтнүүдийн үйл ажиллагааны үр ашигтай, үр дүнтэй байдлыг хангахад шаардлагатай хамтран ажиллагсад болон/эсвэл туслах ажилтнуудыг томилно.
- д) БНСУ-ын мэргэжилтнүүдэд төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай холбогдох тоо баримт, статистик, баримт бичгийг гаргаж өгнө.
- е) БНСУ-ын мэргэжилтнүүдийг Монгол Улсад ажиллахад оршин суухад шаардагдах нэвтрэх, гарах виз, аялалын бичиг баримт болон бусад шаардагдах бичиг баримтыг бүрдүүлэхэд нь захиргааны дэмжлэг үзүүлнэ.
- ф) Солонгос мэргэжилтнүүдэд оффисын талбай, тавилга болон бусад төрлийн шаардлагатай тусламж үзүүлнэ.

Ё. Бусад зардал

Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой Бүгд найрамдах Солонгос улсын Засгийн газрын амлалтаас бусад зардлыг БОАЖЯ хариуцна.

III зүйл. Төслийн хяналт, үнэлгээ

1. Хяналтын баг

БНСУ-ын БОЯ, БОК болон БОАЖЯ-наас томилогдсон хамтарсан баг нь төслийн явц, үр дүн, үйл ажиллагааг хянана.

2. Төслийн үнэлгээ

Хамтарсан баг төслийн дунд хугацааны болон эцсийн үнэлгээг хийнэ. Үнэлгээний үр дүнгийн дагуу Талууд төслийн зорилгод хүрэхэд шаардлагатай гэж үзсэн асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээг авна.

IV зүйл. Төслийг эхлүүлэх, хэрэгжүүлэх

1. Төслийг эхлүүлэх

БНСУ-ын Засгийн газар тухайн оны санхүүгийн жилийн төсвийг баталсны дараа уг төслийг эхлүүлнэ.

2. Төслийг хэрэгжүүлэх

Хэлэлцүүлгийн тэмдэглэлд гарын үсэг зурснаар төсөл хэрэгжиж эхэлнэ.

V зүйл. Хамтын ажиллагаа, зөвшилцөл

1. Хамтын ажиллагаа, зөвшилцөл

Талууд төслийн явцад Ажлын даалгавартай холбоотой үүссэн аливаа зөрчил, маргааныг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр уг Ажлын даалгаварт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

2. Харилцааны хэлбэрүүд

Аль нэг талын ирүүлсэн аливаа харилцаа холбоог бичгээр эсвэл утас, цахим хэрэгслээр дамжуулж, кабель, факс, цахим шуудан гэх мэт дамжуулалтын бодит бүртгэлийг бий болгоно.

3. Цуцлах

Оролцогч бүр Ажлын даалгаврын II зүйлд заасан үүргээ биелүүлэхээ хүлээн зөвшөөрч байна. Талуудын аль нэг нь II зүйлд заасны дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй бөгөөд энэ нь төслийн гүйцэтгэл, хуваарь, зардалд сөргөөр нөлөөлөхөөр байвал төслийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалж болно.

VI зүйл. Төслийг олон нийтэд сурталчлах, ойлголтыг сайжруулах

Төслийн талаар олон нийтэд зөв ойлголтыг бий болгох зорилгоор БОАЖЯ нь төслийг Монголын иргэдэд сурталчлах зохих арга хэмжээг авна.

VII зүйл. Төслийг хэрэгжүүлэх хуваарь

Төслийн урьдчилсан хуваарийг ажлын даалгаврын дараах хавсралтад тусгасан бөгөөд бодит хуваарь болон дэлгэрэнгүй мэдээллийг Талууд цаашид зөвшилцсөний дараа шийдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой.

Хавсралт 1. Төслийн урьдчилсан хуваарь

Хавсралт 2. Байршил

Хавсралт 3. Агаарын чанарын харуулууд ба мэдээллийн технологийн системийн бүрэлдэхүүн хэсэг

Хавсралт 4. Төсвийн урьдчилсан төсөв

Хавсралт 2. Агаарын чанарын хяналтын харуул суурилуулах талбайн байршил
 Агаарын чанарын хяналтын харуулыг дараах 21 байршил, явуулын автомашинд суурилуулна.

д/д	Аймгийн нэр	Харуулын нэр	Байршил		Хэмжилтийн үзүүлэлтийн тоо
			Уртраг	Өргөрөг	
1	Архангай	Цэцэрлэг-01	101.4629	47.47141	3 (PM _{2.5} , SO ₂ ,NO _x)
2	Баянхонгор	Баянхонгор-01	100.72	46.19706	3
3	Баян-Өлгий	Өлгий-01	89.96492	48.96925	3
4	Булган	Булган-01	103.5187	48.81829	3
5	Говь-Алтай	Алтай-01	96.26144	46.37375	3
6	Говьсүмбэр	Чойр-01	108.3743	46.34982	3
7	Дархан-Уул	Дархан-01	105.9065	49.49039	6 (PM _{2.5} , SO ₂ ,NO _x , CO,O ₃ ,PM ₁₀)
8	Дорноговь	Сайншанд-01	110.1353	44.89997	3
9	Дорнод	Чойбалсан-01	114.5088	48.11699	3
10	Дундговь	Мандалговь-01	106.2643	45.74328	3
11	Завхан	Улиастай-01	96.84314	47.74229	3
12	Орхон	Эрдэнэт-01	104.0358	49.03669	6 (PM _{2.5} , SO ₂ ,NO _x , CO,O ₃ ,PM ₁₀)
13	Өвөрхангай	Арвайхээр-01	102.7798	46.26303	3
14	Өмнөговь	Даланзадгад	104.4177	43.57697	3
15	Сүхбаатар	Баруун-Урт	113.2823	46.67286	3
16	Сэлэнгэ	Сүхбаатар-01	106.1924	50.23974	3
17	Төв	Зуунмод-01	106.9517	47.71331	3
18	Увс	Улаангом-01	92.06861	49.97156	3
19	Ховд	Ховд-01	91.37338	48.12634	3
20	Хөвсгөл	Мөрөн	100.1665	49.63872	3
21	Хэнтий	Өндөрхаан-01	110.6242	47.3083	3
22	Улаанбаатар	Хөдөлгөөнт харуул			6

Хавсралт 3. Агаарын бохирдлын хяналтын харуул болон мэдээллийн технологийн системийн бүрэлдэхүүн хэсэг

А. Агаарын чанарын хяналтын харуулын бүрэлдэхүүн хэсэг нь дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Төхөөрөмж	Сэт
1	SO ₂ analyzer	22
2	NO _x хэмжигч	22
3	CO хэмжигч	3
4	O ₃ хэмжигч	3
5	PM ₁₀ хэмжигч	3
6	PM _{2.5} хэмжигч	22
7	Calibrator with O ₃ Photometer	22 /3
8	Zero air generator	22
9	Air sampling manifold	22
10	Data logger	22
11	General weather measuring instrument	22
12	19inch dual Rack	22
13	Air conditioner with and heater	21
14	UPS, AVR	22
15	Container(station)	22
16	Mobile car to accommodate the measurement equipment	1
17	Data transfer program	1
18	Standard gases for calibration.	-
19	Other Consumable and spare parts	-
20	PM 2.5 sequential sampler for the quality control	2
21	Компьютерийн иж бүрдэл	22

* Төслийн явцын төлөв байдлаас шалтгаалан тоног төхөөрөмжийн жагсаалт өөрчлөгдөж болно.

В. Мэдээллийн технологийн системийн техник хангамжийн бүрэлдэхүүн хэсэг нь дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Төхөөрөмж	сэт
1	DB сервер	1
2	WEB сервер	1
3	WAS сервер	1
4	Нөөц сервер	1
5	Харилцаа холбооны сервер	1
6	Статистик/видео хадгалах сервер	1
7	SMS/ Log сервер	1
8	L4 шилжүүлэгч	1
9	Мэдээлэл хадгалах хард	1

* Төслийн явцын төлөв байдлаас хамааран тоног төхөөрөмжийн жагсаалт өөрчлөгдөж болно.

Хавсралт 4. Төсвийн урьдчилсан тооцоо

Үйл ажиллагаа	Валют		Тэмдэглэл
	Солонгос вон	Ам.долла р	
А. Агаарын чанарын хяналтын харуулыг суурилуулах, ажиллуулах			
а. Агаарын чанарын хяналтын харуул байгуулна	7,500 сая	5,814 мянга	
В. Агаарын чанарын мэдээллийн системийг хөгжүүлэх			
в. системийн хөгжүүлэлт	1,200 сая	930 мянга	
С. Чадавх бэхжүүлэх			
а. Мэргэжилтнүүд илгээх, сургалт зохион байгуулах	1,500 сая	1,163 мянга	
Д. Төслийн менежмент ба нөөц төсөв			
Төслийн менежмент ба нөөц төсөв	1,309 сая	1,008 мянга	
Нийт	11,500 сая	8,915 мянга	

1 ам.доллар = 1,290 солонгос вон

* Төсвийн тооцоог төслийн явцын төлөв байдлаас хамааран өөрчилж болно.